



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Цахир сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2026/085/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Аудитор Л.Соёлмөнх
Утас: 7033-3019

Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 86

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Цахир сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Тайлант онд албан хаагчдад тухайн жилийн төсөвт тусгаж батлаагүй 19,580.0 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлтийг цалингийн сангаас олгосон;
2. Өмнөх оны 7,582.7 мянган төгрөгийн өвсний үнэ, тайлангийн жилд илүү шилжүүлсэн 2,080.3 мянган төгрөгийн НДШ, нийт 9663.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй;
3. "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-д заагаагүй 52,000.0 мянган төгрөгийн 3 ажил төлөвлөж, гүйцэтгэлээр 30,998.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;
4. Тээвэр шатахууны зардлын батлагдсан төсвийг хэтрүүлэн Засаг даргын нөөц хөрөнгөөс 5,055.5 мянган төгрөгийг зарцуулсан;

Дээрх 65,298.5 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2, 7.1, Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5, 3.6, 3.7 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,476,623.5 мянган төгрөгийн төсөв батлагдсан ба гүйцэтгэлээр 1,264,179.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Архангай аймгийн Цахир сумын Засаг даргын тамгын газар нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 9 үндсэн зорилтын 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 85.0 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
33	АВЛАГА	9,069,250.00	9,663,010.00
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	2,080,260.00
335	Бусад авлага	9,069,250.00	7,582,750.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	9,069,250.00	7,582,750.00
35	БАРАА МАТЕРИАЛ	89,185,123.00	87,588,023.00
351	Түүхий эд материал	3,282,200.00	14,067,200.00
3511	Тусгай зориулалттай материал	3,282,200.00	14,067,200.00
354	Хангамжийн материал	22,842,923.00	27,680,823.00
3541	Бичиг хэргийн материал	1,919,475.00	1,840,575.00
3542	Аж ахуйн материал	20,923,448.00	25,840,248.00
356	Мал амьтад	63,060,000.00	45,840,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	58,772,000.00	45,942,000.00
363	Тэжээлийн нөөц	58,772,000.00	45,942,000.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	157,026,373.00	143,193,033.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,167,344,381.55	2,292,742,581.65
392	Биет хөрөнгө	1,931,817,048.03	2,057,660,248.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	457,718,410.00	563,737,950.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(100,288,742.48)	(128,566,953.80)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	215,083,115.50	355,583,115.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(94,899,709.43)	(130,840,122.29)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	230,093,055.60	227,629,118.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(104,445,728.54)	(119,223,280.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	102,162,947.00	114,536,729.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(42,969,837.96)	(53,426,703.16)
39209	Зам, гүүрийн байгууламж	524,862,327.00	524,862,327.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(159,018,570.11)	(211,978,894.19)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	204,190,000.00	204,190,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	880,628,139.26	971,024,451.26
39215	Хуримтлагдсан элэгдэл	(196,499,671.81)	(260,927,489.38)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	14,141,314.00	-
39217	Ном	1,060,000.00	1,060,000.00
393	Биет бус хөрөнгө	235,527,333.52	235,082,333.44
39301	Програм хангамж	3,700,000.00	3,700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(576,666.48)	(1,021,666.56)
39303	Бусад биет бус хөрөнгө	232,404,000.00	232,404,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,167,344,381.55	2,292,742,581.65
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,324,370,754.55	2,435,935,614.65
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,109,653.36	5,000,000.00
413	Өглөг	10,109,653.36	5,000,000.00
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	9,600,653.36	-
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	509,000.00	-
4136	Бусад өглөг	-	5,000,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	5,000,000.00
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,109,653.36	5,000,000.00
51	Засгийн газрын хувь оролцоо	2,314,261,101.19	2,430,935,614.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	445,966,870.17	445,966,870.17

512	Хуримтлагдсан үр дүн	1,759,844,927.40	1,876,519,440.86
5121	Өмнөх үеийн үр дүн	1,759,844,927.40	1,759,844,927.40
5122	Тайлант үеийн үр дүн		116,674,513.46
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	108,449,303.62	108,449,303.62
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,314,261,101.19	2,430,935,614.65
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,324,370,754.55	2,435,935,614.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,194,247,108.00	1,450,829,804.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,467,808.00	97,206,304.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,050,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХ,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,417,808.00	97,206,304.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,175,779,300.00	1,353,623,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,175,779,300.00	1,353,623,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	352,551,942.60	493,102,240.00
120	Нийтлэг татварын бус орлого	352,551,942.60	493,102,240.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	154,914,300.00	213,582,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	154,914,300.00	213,582,700.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	197,637,642.60	279,519,540.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,546,799,050.60	1,943,932,044.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,506,726,743.16	1,709,978,817.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,260,319,025.93	1,355,309,558.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	564,279,835.77	671,178,590.15
210101	Үндсэн цалин	379,308,933.25	422,226,878.25
210102	Нэмэгдэл	152,008,332.75	203,858,850.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	20,093,000.00
210104	Урамшуулал	32,962,569.77	24,999,861.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,758,862.36	74,581,741.55
210201	Тэтгэврийн даатгал	56,028,075.56	46,423,260.55
210202	Тэтгэмжийн даатгал	5,653,515.70	6,954,468.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,492,281.85	3,817,890.63
210204	Ажилгүйдлийн даатгал	1,277,957.85	3,477,184.34
210205	Эрүүл мэндийн даатгал	11,307,031.40	13,908,937.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,174,847.00	47,788,666.00
210301	Гэрэл, цахилгаан	8,294,247.00	17,871,720.00
210302	Түлш, халаалт	32,880,600.00	29,916,946.00
2104	Хангамж, бараа материалын зардал	70,688,701.00	75,323,825.00
210401	Бичиг хэрэг	14,371,600.00	13,301,900.00
210402	Тээвэр, шатахуун	38,629,900.00	46,313,875.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,695,000.00	5,738,600.00
210404	Ном, хэвлэл	70,000.00	84,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,259,200.00	1,286,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,663,001.00	8,599,450.00
2105	Нормативт зардал	-	264,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	264,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,354,000.00	1,346,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,354,000.00	1,096,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	250,000.00
2107	Томилолт, зочны зардал	25,014,000.00	26,970,000.00
210702	Дотоод албан томилолт	25,014,000.00	26,970,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,888,149.00	101,621,968.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	99,708,149.00	100,892,010.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	181,170.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	94,688.00	256,788.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	132,000.00
210807	Газрын төлбөр	85,312.00	160,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	349,160,630.80	356,234,767.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	138,156,800.00	134,681,430.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	211,003,830.80	221,553,337.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	246,407,717.23	354,669,258.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,002,000.00	50,156,060.75
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		48,527,810.75
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	44,502,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	1,628,250.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	198,405,717.23	304,513,198.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	198,405,717.23	304,513,198.19
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	103,137,399.00
	Дотоод эх үүсвэрээр	-	103,137,399.00
221001	Их засвар	-	74,621,799.00
223001	Бусад хөрөнгө	-	28,515,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,506,726,743.16	1,813,116,216.54
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	40,072,307.44	130,815,827.46
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	31,407,340.92	14,141,314.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	31,407,340.92	14,141,314.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(31,407,340.92)	(14,141,314.00)
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,664,966.52	116,674,513.46

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,355,956,408.00	1,665,899,004.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	161,709,300.00	215,069,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	161,709,300.00	215,069,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	161,709,300.00	215,069,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	161,709,300.00	215,069,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,194,247,108.00	1,450,829,804.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,467,808.00	97,206,304.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,050,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХ,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,417,808.00	97,206,304.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,175,779,300.00	1,353,623,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,175,779,300.00	1,353,623,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,318,676,408.00	1,481,188,293.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,318,676,408.00	1,481,188,293.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,072,268,690.77	1,126,519,034.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	563,056,344.77	669,542,545.06
210101	Үндсэн цалин	378,085,442.25	429,002,657.01
210102	Нэмэгдэл	152,008,332.75	195,447,026.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	20,093,000.00
210104	Урамшуулал	32,962,569.77	24,999,861.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,381,700.00	87,018,700.00
210201	Тэтгэврийн даатгал	47,859,400.00	58,832,093.71
210202	Тэтгэмжийн даатгал	5,630,600.00	6,961,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,504,500.00	3,821,406.29
210204	Ажилгүйдлийн даатгал	1,126,100.00	3,480,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,261,100.00	13,923,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,174,847.00	47,788,666.00
210301	Гэрэл, цахилгаан	11,182,927.00	17,871,720.00
210302	Түлш, халаалт	29,991,920.00	29,916,946.00
2104	Хангамж, бараа материалын зардал	65,051,200.00	56,469,150.00
210401	Бичиг хэрэг	14,414,600.00	12,406,800.00
210402	Тээвэр, шатахуун	38,606,200.00	33,080,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,940,000.00	6,615,600.00
210404	Ном, хэвлэл	112,000.00	126,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,259,200.00	1,286,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,719,200.00	2,953,800.00
2105	Нормативт зардал	-	10,264,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	10,264,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,354,000.00	6,131,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,354,000.00	1,959,000.00

210604	Урсгал засвар	4,000,000.00	4,172,000.00
2107	Томилолт, зочны зардал	25,000,000.00	26,984,000.00
210702	Дотоод албан томилолт	25,000,000.00	26,984,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	144,964,999.00	73,845,993.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	144,784,999.00	73,116,035.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	181,170.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	94,688.00	256,788.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	132,000.00
210807	Газрын төлбөр	85,312.00	160,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	131,285,600.00	148,474,980.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	131,285,600.00	148,474,980.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	246,407,717.23	354,669,258.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,002,000.00	50,156,060.75
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	48,527,810.75
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	44,502,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	1,628,250.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	198,405,717.23	304,513,198.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	198,405,717.23	304,513,198.19
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	37,280,000.00	184,710,711.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	37,280,000.00	184,710,711.00
	Дотоод эх үүсвэрээр	37,280,000.00	184,710,711.00
221001	Их засвар	-	74,621,799.00
223001	Бусад хөрөнгө	-	28,515,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	37,280,000.00	81,573,312.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(37,280,000.00)	(184,710,711.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	445,966,870.17	108,449,303.62	1,733,044,928.39	2,287,461,102.18
2	Тайлант үеийн үр дүн			126,078,484.15	126,078,484.15
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	445,966,870.17	108,449,303.62	1,759,844,927.40	2,314,261,101.19
10	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	445,966,870.17	108,449,303.62	1,759,844,927.40	2,314,261,101.19
17	Тайлант үеийн үр дүн			116,674,513.46	116,674,513.46
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	445,966,870.17	108,449,303.62	1,876,519,440.86	2,430,935,614.65

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,353,623,500.00	1,049,110,301.81	304,513,198.19	77.5
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,353,623,500.00	1,049,110,301.81	304,513,198.19	77.5
132001	Орон нутгийн төсвөөс	1,353,623,500.00	1,049,110,301.81	304,513,198.19	77.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	123,000,000.00	215,069,200.00	(92,069,200.00)	174.8
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	123,000,000.00	215,069,200.00	(92,069,200.00)	174.8
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,476,623,500.00	1,264,179,501.81	212,443,998.19	85.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,448,107,900.00	1,229,733,901.81	218,373,998.19	84.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,386,642,700.00	1,179,577,841.06	207,064,858.94	85.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	696,149,000.00	669,542,545.06	26,606,454.94	96.2
210101	Үндсэн цалин	696,149,000.00	429,002,657.01	267,146,342.99	61.6
210102	Нэмэгдэл	-	195,447,026.47	(195,447,026.47)	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	20,093,000.00	(20,093,000.00)	
210104	Урамшуулал	-	24,999,861.58	(24,999,861.58)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,018,700.00	87,018,700.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	59,172,800.00	58,832,093.71	340,706.29	99.4
210202	Тэтгэмжийн даатгал	6,961,500.00	6,961,500.00	-	100.0

**Архангай аймгийн Цахир сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210203	ҮОМШӨ-ний даатгал	3,480,700.00	3,821,406.29	(340,706.29)	109.8
210204	Ажилгүйдлийн даатгал	3,480,700.00	3,480,700.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	13,923,000.00	13,923,000.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,214,600.00	47,788,666.00	9,425,934.00	83.5
210301	Гэрэл, цахилгаан	20,214,600.00	17,871,720.00	2,342,880.00	88.4
210302	Түлш, халаалт	37,000,000.00	29,916,946.00	7,083,054.00	80.9
2104	Хангамж, бараа материалын зардал	71,462,000.00	55,885,610.00	15,576,390.00	78.2
210401	Бичиг хэрэг	15,612,000.00	12,406,800.00	3,205,200.00	79.5
210402	Тээвэр, шатахуун	40,000,000.00	32,497,410.00	7,502,590.00	81.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,500,000.00	6,615,600.00	884,400.00	88.2
210404	Ном, хэвлэл	350,000.00	126,000.00	224,000.00	36.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	1,286,000.00	1,714,000.00	42.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	2,953,800.00	2,046,200.00	59.1
2105	Нормативт зардал	12,000,000.00	10,264,000.00	1,736,000.00	85.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,000,000.00	10,264,000.00	1,736,000.00	85.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,000,000.00	23,178,000.00	6,822,000.00	77.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	4,006,000.00	5,994,000.00	40.1
210602	Тавилга	15,000,000.00	15,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,172,000.00	828,000.00	83.4
2107	Томилолт, зочны зардал	30,000,000.00	26,984,000.00	3,016,000.00	89.9
210702	Дотоод албан томиллолт	30,000,000.00	26,984,000.00	3,016,000.00	89.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	193,898,400.00	72,145,028.00	121,753,372.00	37.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	191,966,400.00	71,415,070.00	120,551,330.00	37.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	-	800,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	181,170.00	118,830.00	60.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.00	256,788.00	93,212.00	73.4
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.00	132,000.00	-	100
210807	Газрын төлбөр	350,000.00	160,000.00	190,000.00	45.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	208,900,000.00	186,771,292.00	22,128,708.00	89.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	208,900,000.00	186,771,292.00	22,128,708.00	89.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,465,200.00	50,156,060.75	11,309,139.25	81.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,465,200.00	50,156,060.75	11,309,139.25	81.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,253,200.00	48,527,810.75	725,389.25	98.5
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,712,000.00	-	8,712,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	1,628,250.00	1,871,750.00	46.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,515,600.00	34,445,600.00	(5,930,000.00)	120.8

	Дотоод эх үүсвэрээр	28,515,600.00	34,445,600.00	(5,930,000.00)	120.8
223001	Бусад хөрөнгө	28,515,600.00	28,515,600.00		100.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		5,930,000.00	(5,930,000.00)	
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,476,623,500.00	1,264,179,501.81	212,443,998.19	85.6
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	26	26	-	100.0
6	Удирдах ажилтан	3	3	-	100.0
7	Гүйцэтгэх ажилтан	17	17	-	100.0
8	Үйлчлэх ажилтан	1	1	-	100.0
9	Гэрээт ажилтан	5	5	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	97,206,304.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	97,206,304.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97,206,304.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	97,206,304.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,584,505.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,584,505.00
2104	Хангамж, бараа материалын зардал	583,540.00
210402	Тээвэр, шатахуун	583,540.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,700,965.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,700,965.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	94,621,799.00
	Дотоод эх үүсвэрээр	94,621,799.00
221001	Их засвар	74,621,799.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	97,206,304.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26,800.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 26,800.0 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Тайлант онд Санхүүгийн байдлын тайланд бусад үндсэн хөрөнгө 26.8 сая төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан нь УСНББОУС 1, 17 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1, 13.1 дэх заалт болон аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн байдлын тайлан болон үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар нийт 65,297.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 65,297.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 65,297.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 16,612.0 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Тайлант онд албан хаагчдад тухайн жилийн төсөвт тусгаж батлаагүй 19,580.0 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлтийг цалингийн сангаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, Төсвийн тухай хуулийг мөрдөж, тухайн жилийн төсөвт тусган зөрчлийг арилгаж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.1.2 Байгууллагын 2025 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комиссыг томилоогүй, өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүд тооллогыг 2025 оны 11 дүгээр сард зохион байгуулсан байна. Тооллого хийсэн тэмдэглэл үйлдээгүй, бэлэн байгаа үлдэгдлийг бүрэн тоолж баталгаажуулаагүй, тооллогын акт үйлдээгүй байхад байгууллагын дарга, нягтлан бодогч нар хяналт тавих үүргээ хэрэгжүүлэхгүйгээр нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана", Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж, эд хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, журмын дагуу дахин хийж гүйцэтгэн эргэж хянуулах, байгууллагын удирдлагаас тавих хяналтыг сайжруулж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.1.3 Өмнөх онд өвс борлуулсан 7,582.7 мянган төгрөг, тайлангийн жилд илүү шилжүүлсэн 2,080.3 мянган төгрөгийн НДШ, нийт 9663.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж, Төсвийн тухай хуулийг мөрдөж, өр авлагагүй ажиллахад анхаарч төсвийг зохистой удирдаж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.1.4 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын заалтад хамааралгүй 52,000.0 мянган төгрөгийн 3 ажил төлөвлөж, гүйцэтгэлээр 30,998.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5-т "Энэ журмын 3.4-т заасныг үндэслэн төлбөрийн орлогын хэсгээр тухайн аймаг, нийслэлийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих дараах арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ", 3.6-д "Энэ журмын 3.4-т заасныг үндэслэн төлбөрийн орлогын хэсгээр, энэ журмын 3.5.6, 3.5.7, 3.5.8-д зааснаас гадна тухайн сум, дүүргийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих дараах арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ", 3.7-д "Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, Төсвийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 2-р тогтоолын хавсралтаар баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ыг мөрдөж, зардлыг журмын дагуу төлөвлөж, зарцуулах албан шаардлага хүргүүлээ.

3.1.5 Тээвэр шатахууны зардлын батлагдсан төсвийг хэтрүүлэн Засаг даргын нөөц хөрөнгөөс 5,055.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2-т "Энэ журмын 1.1-д заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно", 7.1-д "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг мөрдөж, батлагдсан төсвийг журмын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлээ.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Залруулсан			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгийг зөрүүтэй тусгасан	1	26,800.0			1	26,800.0	1	26,800.0				
Нийт дүн	1	26,800.0			1	26,800.0	1	26,800.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсөвт тусгалгүй унаа хоолны хөнгөлөлт олгосон	1	19,580.0			1	19,580.0						
Эд хөрөнгийн тооллогыг дутуу хийсэн	1	-			1	-						
Авлага барагдуулах арга хэмжээ аваагүй.	1	9,663.0			1	9,663.0						
БОХНСАХ-ний зардлыг журмын дагуу зарцуулаагүй.	1	30,998.5			1	30,998.5						
Нөөц хөрөнгөөс зориулалт бус зарцуулсан	1	5,055.5			1	5,055.5						
Нийт дүн	5	65,297.0			5	65,297.0						